



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/268

Арвайхээр

“Аймгийн малчдын зөвлөгөөн” зохион байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.4.4.3, 2.4.4.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.3.27 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аймгийн малчдын зөвлөгөөн”-ийг 2019 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Арвайхээр суманд зохион байгуулсугай.
2. “Аймгийн малчдын зөвлөгөөн”-ий үеэр мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөсөн бага оврын шинэ, шинэлэг техник, технологийг нэвтрүүлэх, бизнес эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл, хоршоологчдын шинэ бүтээл оновчтой саналыг дэмжих, олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Шинэ санаа, шилдэг бүтээгдэхүүн”-ий уралдааныг зарласугай.
3. “Шинэ санаа, шилдэг бүтээгдэхүүн”-ий уралдааны удирдамжийг нэгдүгээр, “Аймгийн малчдын зөвлөгөөн”-д шаардагдах нийт зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 4 “Шинэ санаа, шилдэг бүтээгдэхүүн”-ий уралдаан зарлаж, шалгаруулж, дүгнэж, шагнаж урамшуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны тэргүүн (Л.Жаргалбаатар)-т даалгасугай.
5. Хавсралтаар батлагдсан 20.537.000 (хорин сая таван зуун гучин долоо мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100581

Аймгийн Засаг даргын 2019 оны 4...
дүгээр сарын ...ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨНГӨВЧЛӨХӨД ЧИГЛЭГДСЭН
БАГА ОВРЫН ТЕХНИК ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ “ШИНЭ САНАА,
ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Зорилго: Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөсөн бага оврын шинэ, шинэлэг техник, технологийг нэвтрүүлэх, бизнес эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл, хоршоологчдын шинэлэг санаа, санаачлагыг дэмжих, олон нийтэд сурталчилан таниулахад оршино.

Хамрах хүрээ: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэгдсэн бага оврын техник технологи санаачлагч иргэн, хоршоо, аж ахуй нэгжүүд

Бүртгэлийн хугацаа: 2019 оны 04 дугаар сарын 15-аас 05 дугаар сарын 15-ийг хүртэл

Шалгаруулах хугацаа: “Аймгийн малчдын зөвлөгөөн-2019” арга хэмжээ зохион байгуулах үеэр шалгаруулна.

Хаана: Өвөрхангай аймаг Арвайхээр сум

Оролцох бүтээгдэхүүний төрөл:

A/ Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөдөлмөр хөнгөвчлөх чиглэлээр:

- Малын бууц ховхлох, зөөвөрлөх төхөөрөмж
- Хашаа, хорооны шон ухах төхөөрөмж
- Мал саах саалтуур
- Эзэгий, ааруул боловсруулах төхөөрөмж
- Айраг исгэх, бүлэх төхөөрөмж
- Аарц шахах, ааруул хэвлэх, хатаах төхөөрөмж
- Нэхий элдэх төхөөрөмж
- Сур боловсруулах, элдэх төхөөрөмж
- Мах хатаах, утах төхөөрөмж
- Малын арьс, шир хуулах төхөөрөмж
- Мал ноослох, самнах, хяргах, ноос преслэх, ангилж ялгах төхөөрөмж
- Ноос сэмлэх, эсгий хийх төхөөрөмж
- Малын тэжээл үйлдвэрлэх төхөөрөмж
- Мал услах онгоц, ус татах төхөөрөмж
- Хуванцар сав орлох сав
- Малын байршил тогтоох GPS төхөөрөм
- Мал аж ахуйн чиглэлээр хөдөлмөр хөнгөвчлөхөд чиглэгдсэн бусад тоног төхөөрөмж

Б. Малын хашаа, саравч:

- Тэмээ ноослох хашаа
- Зөөврийн хашаа
- Мод орлуулах материалаар хашаа хийх
- Зөөврийн гэр, байшин
- Отрын угсардаг зуух
- Зөөврийн багийн төв

Аймгийн Засаг даргын 2019 оны
... дугаар сарын 25-ны өдрийн А/268 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Зардлын нэр | | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ мян/төг | Бүгд үнэ мян/төг |
|-----|-----------------|----------|-------------------|-----|------------------------|------------------|
| 1. | Өдрийн хоол | 1-р хоол | Порц | 400 | 5500 | 2200.0 |
| 2. | | 2-р хоол | Порц | 400 | 9000 | 3600.0 |
| 3. | Оройн хоол | | | 400 | 13000 | 5200.0 |
| 4. | Аннос | | 42 М ² | 1 | 6500 | 273.0 |
| | | | 48 М ² | 1 | 8000 | 384.0 |
| 5. | Урилга хөтөлбөр | | Ш | 400 | 1500 | 600.0 |
| 6. | Мандат | | Ш | 400 | 700 | 280.0 |
| 7. | Гарын авлага | | Ш | 400 | 1500 | 600.0 |
| 8. | Уут | | Ш | 400 | 2000 | 800.0 |
| 9. | Дурсгалын зүйл | | Ш | 400 | 12000 | 4.800.0 |
| 10. | Цайны материал | | Ш | 400 | 1500 | 600.0 |
| 11. | Бусад зардал | | | 400 | 3000 | 1.200.0 |
| | Нийт зардал | | | | | 20537.0 |

В. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах арга, технологи:

- Малын бууц ашиглан био бордоо хийх
- Шар сүү боловсруулах арга, технологи
- Яс боловсруулах арга, технологи
- Малын тос, өөх боловсруулах арга, технологи
- Малын хөөвөр, хялгас, саваг ашиглан хийсэн бүтээгдэхүүн
- Малын эвэр, туруу ашиглах, боловсруулах арга, технологи
- Малын цус боловсруулах арга, технологи

Шалгаруулалт: Төрөл тус бүр дээр ажлын хэсэг дүгнэн шалгаруулна.

1. Шалгаруулалтанд оролцох иргэн, аж ахуй нэгж нь мал аж ауйн үйлдвэрлэлийг хөнгөвчилсөн шинэ санал, санаачлага гаргасан байна.
2. Уралдаан, шалгаруулалтанд ирүүлэх материал
 - Бүтээгдэхүүн, техникийн танилцуулга
 - Бүтээгдэхүүн, техник биетээр байх.
 - Үйлдвэрлэгч иргэн, аж ахуй нэгжийн танилцуулга

Хамтран зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар, Аймгийн Засаг даргын тамгын газар, Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо